



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/56

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 тогтоолоор баталсан Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардлаас 204,985,200 (хоёр зуун дөрвөн сая есөн зуун наян таван мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д олгосугай.

2. Дээрх зардлын 204,985,200 (хоёр зуун дөрвөн сая есөн зуун наян таван мянга хоёр зуун) төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу Засаг дарга дансны “Ариун цэврийн байгууламжийн тогтмол зардал”-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Лхагважав)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН